



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ  
СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ  
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН  
ТУШААЛ

2017 оны 01 сарын 10 өдөр

Дугаар А/14

Улаанбаатар хот

Төлбөртэй тусламж үйлчилгээний тухай

Монгол улсын “Эрүүл мэндийн тухай” хуулийн 24.1, “Сэтгэцийн эрүүл мэндийн тухай” хуулийн 8.1., 8.2, “Төсвийн тухай” хууль, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2006 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 370/387 тоот хамтарсан тушаал, Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А/228 дугаар тушаалууд болон 2017 онд төвийн батлагдсан төсөвт үйл ажиллагааны нэмэлт орлогоор 441 /дөрвөн зуун дөчин нэгэн сая/ төгрөгийг оруулах төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлагуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд төлбөртэй тусламж үйлчилгээ явуулах журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Клиникүүдэд төлбөртэй ажиллуулах орны тоо, төлбөрийн хэмжээ”-г хоёрдугаар хавсралтаар, “Нэмэлт төлбөртэй үзлэг, шинжилгээ оношлогоо, эмчилгээний үнийн тариф”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төлбөртэй эмчилгээний журамд заасан үйлчлүүлэгчдэд эмчилгээ үйлчилгээг чанартай хийж, эмч эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээний дагуу харьцаж, үйлчлүүлэгч болон тэдний ар гэрийнхэнд сэтгэл ханамж үүсгэн үйлчилж байхыг клиник, тасгийн эрхлэгч, багийн ахлагч болон нийт эмч нарт даалгасугай.


3. Төлбөртэй эмчилгээ, үйлчилгээний үйл ажиллагааг санхүүгийн хууль дүрмийн дагуу явуулж, хяналт тавин удирдан ажиллахыг Стратеги төлөвлөлт, хүний нөөцийн хөгжил, мэдээллийн технологи эрхэлсэн дэд захирал /О.Баатаржав/, Санхүү бүртгэлийн албаны дарга, ахлах нягтлан бодогч /Н.Энхжаргал/, дотоод аудитор /С.Чогсом/ нарт үүрэг болгосугай.

4. Энэ тушаалын биелэлтэнд байнгын хяналт тавин эмчилгээ үйлчилгээний чанарт анхаарч, эмнэлэг хамгаалал, ёс зүй харьцаа хандлагын зөрчил гаргуулахгүй, үйлчлүүлэгч нарт сэтгэл ханамж үүсгэн ажиллахыг

Эмчилгээ эрхэлсэн дэд захирал /О.Ганчулуун/, Чанарын албаны дарга /Н.Оюунчимэг/, Поликлиникийн эрхлэгч /Д.Дэжидмаа/ нарт үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан СЭМҮТ-ийн Ерөнхий захирлын 2015 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 75 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Л.НАСАНЦЭНГЭЛ

